



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН "БАТШИРЭЭТ"
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 6/21.

Батширээт сум

**Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
гишүүдийг өөрчлөх тухай**

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтыг үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Батширээт" сум дундын ойн ангийн дэргэдэх орон тооны бус "Өмч хамгаалах" байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй өөрчилж байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Б. Батчимэг	/ Ойн инженер/
Гишүүд:	Б. Дуламжав	/ Ойн техникч /
	Г. Ганзолбоо	/ Жолооч /

2. Байгууллагын үндсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон зайлшгүй шаардлагатай эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллан, үр дүнг танилцуулж байхыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Б. Батчимэг)-д үүрэг болгосугай.



Г.ГАНТУЯА

• 242501021